



“МОНГОЛ ШУУДАН” ХК

“ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЗАР

Компанийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1 дэх заалт, 81 дүгээр зүйлийн 81.5 дахь заалтыг тус тус үндэслэн “Монгол шуудан” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүний сонгон шалгаруулалтыг зарлаж байна.

Тавигдах шаардлага:

1. Мэргэжил: Мэдээллийн технологи, харилцаа холбоо, тээвэр, логистик, олон улсын худалдаа, банк санхүү, бизнесийн удирдлага, хууль эрх зүйч;
2. Ёс зүйн болон бизнесийн нэр хүнд нь компанийг удирдахад харшлахгүй байх;
3. Компанийн засаглалын сургалтанд хамрагдсан байх;
4. Бизнесийн салбарт удирдах албан тушаалд 5-с доошгүй жил ажилласан туршлагатай байх;

Сонгон шалгаруулалтад оролцохыг хязгаарлах нөхцөл:

- Тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг нь шүүхийн шийдвэрээр хаасан, эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдэж шүүхээр шийтгүүлсэн;
- Төрийн үйлчилгээнээс бусад төрийн алба хашдаггүй;
- Өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь “Монгол шуудан” ХК-д ажил албан тушаал эрхэлдэг, эсхүл сүүлийн 3 жилийн хугацаанд ажил албан тушаал эрхэлж байсан;
- “Монгол шуудан” ХК-тай бизнесийн хэлхээ холбоотой байх;

Бүрдүүлэх материал:

- Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт,
- Өмнө эсвэл одоо ажиллаж байгаа газраас гаргасан ажил байдлын тодорхойлолт,
- Анкет (төрийн албан хаагчийн анкетийн загвар дээр),
- 2 хувь цээж зураг,
- Боловсролын диплом, үнэмлэхний нотариатаар баталгаажсан хуулбар,
- Иргэний үнэмлэхний хуулбар,
- Компанийн засаглалын гэрчилгээний нотариатаар баталгаажсан хуулбар,

Сонгон шалгаруулалтын материал хүлээн авах хаяг:

Улаанбаатар хот, Төв шуудангийн баруун хаалга, “Монгол шуудан” ХК-ийн байр, ТУЗ-ийн НБД-д хүлээлгэж өгөх, Утас: 99120278, 91920278

Материал хүлээн авах хугацаа:

Сонгон шалгаруулалтад орох иргэний өргөдөл, материалыг **2023** оны **03** сарын **10**-ны өдрийн **17:00** цаг хүртэл авна.

Хүлээлгэн өгч байгаа материал битүүмжлэгдсэн байх ба дээр нь хаяг, холбоо барих утасны дугаарыг бичнэ.

Жич: Хэрэв та хараат бус гишүүнд сонгогдсон тохиолдолд Хөрөнгө, орлогын мэдүүлэг мэдүүлэх үүрэг хүлээнэ.

“МОНГОЛ ШУУДАН” ХК-ИЙН ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ
ЗАСАГЛАЛ, НЭР ДЭВШҮҮЛЭХ, ЦАЛИН УРАМШУУЛЛЫН ХОРОО

2023.02.17